

## ӨМНӨХ ҮГ

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, МУИС-ийн ЭЗС-ийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төвтэй хамтран НҮБ-ын ХАС-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 18 дахь дугаарыг бэлтгэн, эрхэм уншигч Та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийнхээ энэ дугаарын **“Судалгаа”** хэсэгт улс орнуудын эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч гол үзүүлэлт болох дотоодын нийт бүтээгдэхүүнийг Монгол Улсад тооцож буй статистикийн аргачлалыг боловсронгуй болгох зарим асуудал, хүний хөгжлийн түвшинг хэмжигч хүний хөгжлийн индекст өөрийн орны үндэсний онцлогийг тусгах арга зүйн зарим асуудлууд, төвөөс алслагдсан аймгуудын нэг болох Завхан аймгийн хүн ам зүйн орчны судалгаа, хүн амын амьжиргааг дээшлүүлэх боломжид нөлөөлөгч арилжааны банкнуудын мэдээллийн системийн онцлог асуудлууд, Монголын арилжааны банкуудын туршлага, цаашдын хандлага зэрэг онол, практикийн хэлцэмж бүхий судалгаа, эрдэм шинжилгээний ажлуудын үр дүнг танилцуулж байна.

Харин **“Сургалт”** хэсгийг уншиж, судалснаар Монгол улс мэдлэгт суурисан эдийн засагт шилжих хөгжлийн стратегийн асуудлын талаар Та мэдлэгийнхээ хүрээг тэлэх боломжтой боллоо.

Монголын хүн амын гэрлэлтийн генетик тогтцыг судлах хэрэгцээ, шаардлагын талаар эрдэмтэдийн дэвшүүлж буй үндэслэлийг **“Үзэл бодол”** хэсгээс уншиж танилцахын ялдамд уншигч Та өөрийн үзэл бодлоо манай сэтгүүлээр дамжуулан хуваалцаарай.

Сэтгүүлийнхээ **English** хэсэгт Монгол Улсын хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх хууль, тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийн талаар болон албан бусаар алт олборлож буй хүүхдүүдийн сургуульд хамрагдаагүй шалтгааныг тодорхойлогч хүчин зүйлс зэрэг эрдэм шинжилгээний ажлуудын үр дүнг нийтэллээ.

Сэтгүүлийнэнэудаагийн дугаарт толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, манай дараагийн дугаарт өөрийн материалыа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэ ялдамд, хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, эрдэм шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид, оюутнууддаа болон уг сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлж байгаа НҮБ-ын ХАС-гийн суурин төлөөлөгчийн газарт сэтгүүлийн редакцийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

## РЕДАКЦЫИН ЗӨВЛӨЛ